



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/563

Алтай хот

**“Улсын хил хамгаалалтад туслах хүчний
зөвлөл”-ийн нэгдсэн зөвлөгөөн зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигаар баталсан “Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам”-ын 3.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Улсын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл”-ийн (цаашид “зөвлөл” гэх) нэгдсэн зөвлөгөөнийг 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулахыг Зөвлөлийн орлогч, Хилийн 0214 дүгээр ангийн захирагч (хурандаа В.Батжаргал)-д үүрэг болгосугай.


2.Зөвлөгөөнөөр зөвлөлийн 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, 2022 онд хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах асуудлыг хэлэлцэхийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т даалгасугай.

3.Зөвлөгөөнд оролцох бүрэлдэхүүний нэрсийг нэгдүгээр хавсралтаар, зөвлөгөөний хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 20~~21~~²² оны
!! дугаар сарын ~~29~~²⁸-ны өдрийн ~~1563~~¹⁵⁶² дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

**“УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ
ЗӨВЛӨЛ”-ИЙН НЭГДСЭН ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦОХ
БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭРС**

Зөвлөлийн дарга:	О.Амгаланбаатар	-(Аймгийн Засаг дарга)
Зөвлөлийн орлогч дарга:	В.Батжаргал	-(Хилийн 0214 дүгээр ангийн захирагч, хурандаа)
Гишүүд:	Д.Даваадорж	-(Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга)
	Ц.Эрдэнэбат	-(Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга,
	Х.Баатарзориг	-(Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
	Д.Төмөрбаатар	-(Аймгийн Цэргийн штабын дарга)
	Ш.Баттогтох	-(Аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч)
	Б.Билэгсайхан	-(Аймгийн Прокурорын газрын дарга)
	Н.Эрдэнэ-Очир	-(Аймгийн Цагдаагийн газрын дарга)
	Ж.Баянбаатар	-(Аймгийн Онцгой байдлын газрын дарга)
	Д.Батгэрэл	-(Тагнуулын Ерөнхий газрын аймаг дахь хэлтсийн дарга)
	Н.Бадамсамбуу	-(Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга)
	Ч.Баярбат	-(Говийн их дархан цаазат газрын “А” хэсгийн хамгаалалтын захиргааны дарга)
	О.Ганбаатар	-(Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн хамгаалалтын захиргааны дарга)
Нарийн бичгийн дарга:	Ц.Батзориг	-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
	Хилийн сумдын хил хамгаалалтад туслах хүчний салбар зөвлөлийн дарга нарын нэрс	
М.Насанбат	-(Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг дарга)	
Ч.Дашням	-(Говь-Алтай аймгийн Бугат сумын Засаг дарга)	
Д.Эрдэнэжаргал	-(Говь-Алтай аймгийн Алтай сумын Засаг дарга)	
Л.Насанбуян	-(Говь-Алтай аймгийн Цогт сумын Засаг дарга)	
Э.Давааням	-(Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга)	

Аймгийн Засаг даргын 2021 оны
11 дугаар сарын 29-ны өдрийн 1156 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ЗӨВЛӨГӨӨНИЙ ХӨТӨЛБӨР

2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр:

15.30-16.00	Зөвлөгөөнд оролцох бүрэлдэхүүнийг хүлээн авах- хошууч А.Ажилчин
16.00-16.05	Зөвлөгөөнийг нээх-хурандаа В.Батжаргал
16.05-16.15	Зөвлөгөөнийг нээж үг хэлэх-аймгийн Засаг дарга, ХХТХЗ-ийн дарга үг хэлэх О.Амгаланбаатар
16.15-16.25	Хилийн 0214 дүгээр ангийн захирагч үг хэлэх-хурандаа В.Батжаргал
16.25-16.35	ХХТХЗ, ХХТХСЗ-тэй 2021 онд хамтран ажилласан дүнг танилцуулах-хошууч А.Ажилчин
16.35-17.00	ХХТХЗ, ХХТХСЗ-тэй 2022 онд хамтран хийгдэх ажлын талаар хэлэлцэх- ХХТХЗ-ийн дарга, гишүүд
17.00-17.20	ХХТХЗ, ХХТХСЗ-тэй 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөнүүдийг баталгаажуулах-хошууч А.Ажилчин
17.20-17.25	Зөвлөгөөнийг хаах-хурандаа В.Батжаргал
17.40-18.40	Хүндэтгэлийн зоог барьж, урлагийн номер үзэх-ахмад Г.Сүхбаатар
18.40-19.00	Зөвлөгөөнд оролцогсдыг үдэх -хошууч А.Ажилчин